



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/86

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 28 дугаар зүйлийн 28.7.2, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3, 32 дугаар зүйлийн 32.1.4, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 04 дүгээр “Сумын 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/75 дугаар захирамж, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний 62 дугаар “Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Улс орон даяар өвөлжилт хүндэрч зудын эрсдэлт нөхцөл байдал үүссэнтэй холбоотой Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд Сэг зэм устгалын ажлыг зохион байгуулж, сэг зэм устгалын 5 цэг байгуулах ажилд 26,100,000 (хорин зургаан сая нэг зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Сэг зэм устгалын ажилд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Сэг зэм устгалын ажилд зарцуулагдах 26,100,000 (хорин зургаан сая нэг зуун мянга) төгрөгийг холбогдох хууль, журмын дагуу баримт бичгийн бүрдлийг хангаж, Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.


4. Тус ажлыг чанартай зохион байгуулж, стандартын шаардлагыг мөрдлөг болгон ажиллахыг Сэг зэм устгалын ажлын хэсэгт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 1186 дугаар захирамжийн хавсралт



СЭГ ЗЭМ УСТГАЛЫН АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Нэгж үнэ	Тоо хэмжээ	Нийт дүн
1	Шатахууны зардал			13,000,000
2	Томилолтын зардал	90,000	127	11,430,000
3	Хоол хүнсний зардал			1,670,000
НИЙТ ДҮН				26,100,000